

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2023/78/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он</p>	<p>Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Ч.Баярсайхан Утас: 89000060 Цахим хаяг: bayaraach85@yahoo.com Аудитын менежер: Г.Ганцэцэг Утас:88883775 Цахим хаяг: jni.gantsetseg@gmail.com Аудитор: Э.Нандинчимэг Утас:88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com</p>
-----------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	9
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	10
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	11
4.1 Ерөнхий зүйл.....	11
4.2 Материаллаг байдал	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	14

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НӨҮГ	Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И мэйл: ub@audit.gov.mn, Вeбсайт: www.audit.mn

2023.03.15 № 723

танай _____ -ны № _____ -т

ӨСВӨР ҮЕ ХҮНС
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Г.МӨНХЗУЛ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус хэлтэс нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

D:\Desktop\2023\Монгол Улсын Банк\2023.03.15\Өсвөр үе.docx

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч биелэлтийг дүгнээгүй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	01 сарын 01	12-р сарын 31
1	Хөрөнгө		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	30,840,625.47	53,199,651.27
1.1.2	Дансны авлага	-	1,880,780.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	26,000.00	-
1.1.4	Бусад авлага	6,280,000.00	2,000.00
1.1.6	Бараа материал	67,108,547.43	135,091,519.45
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	353,000.00	5,086,666.67
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	104,608,172.90	195,260,617.39
1.2.1	Үндсэн хөрөнгө	176,793,912.50	189,321,029.23
1.2.2	Биет бус хөрөнгө	37,668,120.00	36,768,120.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	214,462,032.50	226,089,149.23
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	319,070,205.40	421,349,766.62
2.1.1.1	Дансны өглөг	2,145,000.00	1,375,000.00
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	98,378,361.82	32,298,053.67
2.1.1.4	НДШ - ийн өглөг	-	39,900.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	54,303,280.00	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	2,684,035.00	2,684,035.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	26,000.00	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	157,536,676.82	36,396,988.67
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	157,536,676.82	36,396,988.67
2.3	Эздийн өмч	155,762,196.93	155,762,196.93
2.3.1	төрийн	155,762,196.93	155,762,196.93
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	21,679,471.32	21,679,471.32
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	36,768,120.00	36,768,120.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-52,676,259.67	170,742,989.70
2.3.11	Эздийн өмчийн дүн	161,533,528.58	384,952,777.95
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	319,070,205.40	421,349,766.62

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,772,369,527.91	7,700,404,343.81
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,545,610,315.68	6,843,444,674.01
3	Нийт ашиг (алдагдал)	226,759,212.23	856,959,669.80
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	1,621,190.94
8	Бусад орлого	543,003.26	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	365,516,966.80	582,168,844.12
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	7,230,784.26	25,351,565.59
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(145,445,535.57)	251,060,451.03

Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

19	Орлогын татварын зардал	54,300.33	27,641,201.66
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(145,499,835.90)	223,419,249.37
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(145,499,835.90)	223,419,249.37
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	(145,499,835.90)	223,419,249.37

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	155,762,196.93	21,679,471.32	36,768,120.00	92,823,576.23	307,033,364.48
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(145,499,835.9)	(145,499,835.9)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
2022 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	155,762,196.93	21,679,471.32	36,768,120.00	(52,676,259.67)	161,533,528.58
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	155,762,196.93	21,679,471.32	36,768,120.00	(52,676,259.67)	161,533,528.58
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	223,419,249.37	223,419,249.37
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	155,762,196.93	21,679,471.32	36,768,120.00	170,742,989.7	384,952,777.95

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	1,975,645,965.26	8,521,754,213.07
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,947,053,734.00	8,468,563,998.80
1.1.6	Бусад мөнгөн орлого	28,592,231.26	53,190,214.27
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,051,715,578.48	8,374,756,207.27
1.2.1	Ажиллагчдад төлсөн	198,598,705.88	300,782,150.61
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	61,269,494.80	91,530,086.17
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,672,494,020.70	7,168,076,532.00
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	8,965,125.10	24,807,936.78
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,557,000.00	25,981,479.23
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	54,822,333.00	658,098,979.51
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	531,360.00	465,210.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	48,477,539.00	105,013,832.97
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-76,069,613.22	146,998,005.80
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	0.00	0.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	2,899,990.00	70,335,700.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,899,990.00	70,335,700.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-2,899,990.00	-70,335,700.00
3	Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	0.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	9,000,000.00	54,303,280.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	9,000,000.00	54,303,280.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(9,000,000.00)	(54,303,280.00)
4	Валютын ханшийн зөрүү	0.00	0.00
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(87,969,603.22)	22,359,025.80
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	118,810,228.69	30,840,625.47
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	30,840,625.47	53,199,651.27

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2021 оны гүйцэтгэл	2022 оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого	1,772,912,500.00	9,529,469,530.00	7,702,025,530.00	1,827,444,000.00	81%
Борлуулалтын орлого	1,772,369,500.00	9,528,919,530.00	7,700,404,340.00	1,828,515,190.00	81%
Бусад орлого	543,000.00	550,000.00	1,621,190.00	(1,071,190.00)	295%
Нийт зардал	1,918,358,100.00	9,487,954,298.44	7,450,965,070.00	2,036,989,228.44	79%
ББӨ	1,545,610,300.00	8,662,654,128.44	6,843,444,670.00	1,819,209,458.44	79%
Цалин	222,501,100.00	489,783,660.00	345,485,000.00	144,298,660.00	71%
Хоол унааны зардал	21,489,000.00	47,127,600.00	39,496,600.00	7,631,000.00	84%
Нийгмийн даатгалын шимтгэл	32,323,000.00	67,113,910.00	47,971,400.00	19,142,510.00	71%
Шуудан холбоо	3,941,700.00	5,749,600.00	3,995,590.00	1,754,010.00	69%
Цахилгаан	1,105,200.00	15,240,000.00	10,587,980.00	4,652,020.00	69%
Шатахуун	8,895,900.00	19,822,000.00	21,949,070.00	(2,127,070.00)	111%
Бичиг хэрэг	2,711,000.00	5,040,000.00	4,234,560.00	805,440.00	84%
Хөдөлмөр хамгаалал	6,376,300.00	9,980,000.00	5,100,910.00	4,879,090.00	51%
Ашиглалтын зардал	1,405,300.00	5,152,000.00	5,329,290.00	(177,290.00)	103%
Хангамжийн материал	2,722,500.00	9,240,000.00	8,454,980.00	785,020.00	92%
Засварын зардал	2,633,900.00	17,000,000.00	13,432,930.00	3,567,070.00	79%
Түрээсийн зардал	-	24,500,000.00	12,413,330.00	12,086,670.00	51%
Элэгдлийн зардал	40,585,700.00	40,653,400.00	40,291,400.00	362,000.00	99%
Сэлбэг хэрэгсэл	5,176,200.00	8,750,000.00	8,621,270.00	128,730.00	99%
Сургалтын зардал	240,000.00	2,420,000.00	400,000.00	2,020,000.00	17%
Албан томилт	-	15,000,000.00	-	15,000,000.00	0%
Бусад зардал	12,435,700.00	14,625,000.00	12,665,200.00	1,959,800.00	87%
Татвар, даатгал	974,500.00	1,908,000.00	1,739,320.00	168,680.00	91%
Үйл ажиллагааны зардал	365,517,000.00	799,105,170.00	582,168,830.00	216,936,340.00	73%
Үйл ажиллагааны бус зардал	7,230,800.00	26,195,000.00	25,351,570.00	843,430.00	97%
Татвар төлөхийн өмнөх ашиг	(145,445,600.00)	41,515,231.56	251,060,460.00	(209,545,228.44)	605%
Орлогын татварын зардал	54,300.00	6,771,020.00	27,641,200.00	(20,870,180.00)	408%
Цэвэр ашиг	(145,499,900.00)	34,744,211.56	223,419,260.00	(188,675,048.44)	643%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 154 дугаар тогтоолоор нийслэлийн Баянзүрх, Хан-Уул дүүргүүдэд үйл ажиллагаагаа явуулж байсан “Балчирхан”, “Хан-Уул Хангамж” НӨҮГ-уудыг нэгтгэснээр үүсгэн байгуулагдсан.

Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ “нийслэлийн Багахангай, Баянзүрх, Хан-Уул дүүргүүдийн сургуулийн өмнөх боловсролын 83 байгууллага, ерөнхий боловсролын 15 сургуулийн нийт 165 хичээлийн байрны хүүхэд багачуудыг эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан, баталгаатай, чанартай хүнсний бараа бүтээгдэхүүнээр тасралтгүй хангах” үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

Байгууллагын эрхэм зорилго нь “Ханган нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг олшруулах, хүүхдийн насны онцлогт тохирсон илчлэг сайтай, шимт бодисын хэрэгцээ, витаминлаг байдлыг бүрэн хангасан хүнсээр хангах, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг цаашид дотоодын гарал, үүсэлтэй бүтээгдэхүүнээр бүрэн хангах”-д оршино.

Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ нь Байгууллагын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, зардлыг хэмнэх үүднээс цэцэрлэгийн нийтийн хоолны тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, мал аж ахуй, газар тариалан зэргээр туслах аж ахуй эрхэлж үйл ажиллагааны цар хүрээгээ тэлэх юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль зэрэг эрхзүйн актуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- 2022 оны 04 дүгээр сарын 29-нд батлагдсан “Төрийн хэмнэлтийн тухай” хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллага нь дотоод аудитын ажилтангүй бөгөөд Нийслэлийн засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 2022 оны А/1592 захирамжийн дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдэж 2023 оны 03/132 албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн байна. Мөн Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны А/24 дүгээр тушаалаар “Нийслэлийн сургууль, цэцэрлэгүүдэд хүнс, хангамжийн материал нийлүүлдэг ОНӨААТҮГ-уудын шилэн данс, худалдан авах ажиллагаа”-нд нийцлийн аудит хийгдэж, зөвлөмж өгсөн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс

үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ нь байгууллагын удирдлагын 2018 оны А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байна. Тайлант онд захирлын 2022 оны А/11 дугаар тушаалаар “Дансны код”-д өөрчлөлт орсон байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 102,279.6 мянган төгрөгөөр буюу 32.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	30,840.6	53,199.7	22,359.0
Авлага	6,306.0	1,882.8	(4,423.2)
Урьдчилгаа	353.0	5,086.7	4,733.7
Бараа материал	67,108.5	135,091.5	67,983.0
Үндсэн хөрөнгө	214,462.0	226,089.1	11,627.1
Нийт хөрөнгө	319,070.2	421,349.8	102,279.6
Өр төлбөр	157,536.7	36,397.0	(121,139.7)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	161,533.5	384,952.8	223,419.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	319,070.2	421,349.8	102,279.6

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй дараах өөрчлөлт гарчээ. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдлийн 315.6 мянган төгрөг кассад, 52,884.1 мянган төгрөг арилжааны банкны харилцах дансанд тус тус байна.

Бараа материал дансны үлдэгдэл 135,091.5 мянган төгрөг болж өмнөх оноос 67,983.0 мянган төгрөгөөр өссөн нь цэцэрлэгүүдийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, бараа материалын татан авалт нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 226,089.1 мянган төгрөг болж өмнөх оноос 11,627.1 мянган төгрөгөөр өссөн нь Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1454 дүгээр захирамж, НӨХГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 1/1545 дугаар албан бичгийн дагуу 35,400.0 мянган төгрөгийн өртөгтэй хьюндай аванте маркийн албан хэрэгцээнд ашиглагддаг тээврийн хэрэгслийг Нийслэлийн Төр захиргааны Авто бааз УТҮГ-т шилжүүлэн данснаас хассан байна. Мөн НӨХГ-т 2022 оны 2 дугаар сарын 17-ны А/34 дүгээр тушаалаар 15,780.0 мянган төгрөгийн

мицубиши каньер маркийн автомашиныг сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж данснаас хассан ба НӨХГ-ын 2022 оны 2/1035 дугаар албан бичгээр хүнсний ханган нийлүүлэлтийг тасралтгүй явуулахын тулд автомашин худалдан авч болох зөвшөөрлийг ирүүлснээр 51,180.0 мянган төгрөгийн түгээлтэд ашиглах автомашиныг өөрийн хөрөнгөөр худалдан авсан.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 36,397.0 мянган төгрөг болж өмнөх оноос 121,139.7 мянган төгрөгөөр буурсан нь нэмэгдсэн өртгийн албан татварын өр 81,842.0 мянга, ногдол ашгийн өр 54,303.3 мянган төгрөгийг төлж, ААНОАТ-ын өр 15,834.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс голлон шалтгаалжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу байгууллагын удирдлага нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/488 дугаар захирамжаар 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 9,529,469.5 мянган төгрөгөөр, нийт зардлыг 9,494,725.3 мянган төгрөгөөр, цэвэр ашгийг 34,744.2 мянган төгрөг, тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 11,900.0 мянган төгрөг байхаар тогтоосон тухай НӨХГ-ын 2022 оны 2/451 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

Гүйцэтгэлээр 7,702,025.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 6,843,444.7 мянган төгрөгийн зардал гарган, 223,419.3 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 7,702,025.5 мянган төгрөг болж төлөвлөснөөс 1,827,444.0 мянган төгрөг буюу 20.0 хувиар тасарсан нь цар тахлаас шалтгаалан 1, 2 дугаар сард цэцэрлэг ажиллаагүй, 1.5-3 хүртэлх насны хүүхдүүдийг 1-5 сарын хугацаанд цэцэрлэгт хамруулаагүй хүүхдийн ирц бүрдээгүйгээс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 7,450,965.1 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 2,036,989.2 мянган төгрөг буюу 21.4 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь орлогын гүйцэтгэлээс шууд хамаарч бараа материалын зардал бага гарснаас гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 223,419.3 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 188,675.1 мянган төгрөгөөр илүү байгаа нь цалингийн зардал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, түрээсийн зардал, албан томилолт зэрэг зардлуудыг дутуу зарцуулснаас нөлөөлжээ.

НӨХГ-т тайлант онд өмнөх оны ногдол ашгийн өрийн үлдэгдэл 54,303.3 мянган төгрөгийг төвлөрүүлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахаар шилэн данс болон болзошгүй өр төлбөртэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан консалтинг аудит ХХК-ийн аудитор Э.Нандинчимэг, аудиторын туслах Б.Саруулзаяа нар гүйцэтгэж, хяналтыг гүйцэтгэх захирал Ч.Баярсайхан, чанарын хяналтын менежер Г.Ганцэцэг, НТАГ-ын санхүү-нийцлийн хэлтсийн аудитын менежер Д.Отгонбаяр, хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангаа Хаан консалтинг аудит ХХК-д 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайланг, суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 1,772,369.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 17,723.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Нийслэлийн засаг даргын 2022 оны А/1454 дүгээр захирамж, НӨХГ-ын 2022 оны 1/1543 дугаар албан бичгээр албан хэрэгцээнд ашиглагдаж байсан 35,400.0 мянган төгрөгийн өртөгтэй тээврийн хэрэгслийг Нийслэлийн төр захиргааны авто бааз УТҮГ-т шилжүүлсэн зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд албан тушаалын автомашинтай холбоотой цалингийн зардлыг 7,255.7 мянга, шатахууны зардлыг 1,280.0 мянга, сэлбэг хэрэгсэл угаалгын зардлыг 240.0 мянган төгрөгөөр хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,

нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 186 мэдээллээс хугацаандаа оруулсан 171, батлагдсан орон тооны өөрчлөлт, Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт, төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл зэрэг хугацаа хоцроосон 5 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх" заалттай нийцээгүй, "эрх үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн мэдээлж ажиллах зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Захирлын нэг тушаалыг буруу ангиллаар гаргасан байна. Энэ нь Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын 3 дугаар зүйл Байгууллагын үйл ажиллагааг баримтжуулах 3.2.1 Байгууллага нь үндсэн үйл ажиллагааны болон хүний нөөцийн чиглэлээр тус тусад нь тушаал, захирамж гаргана 3.2.1.2 "Тэтгэмж олгох, туслалцаа үзүүлэх" заалттай нийцээгүй, "үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох журмыг мөрдөж ажиллах, буруу ангиллаар тушаал гаргасан зөрчлийг арилгах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалт болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 200.5 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, 4,000.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг 100.0 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 2 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	200.5	1	200.5	100.0
Албан шаардлага	1	4,000.0	1	4,000.0	100.0
Зөвлөмж	1	-	1	-	100.0
Нийт дүн	3	4,200.5	3	4,200.5	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Зорилтот түвшний төлөвлөлтийг зардлын ангиллаар үнэн зөв боловсруулан батлуулж, зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой санхүүгийн тайланд залруулга хийгдэх асуудал илрээгүй байна.

Аудитаар нийт 869.7 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 609.7 мянган төгрөгийн төлбөрийн акт, 260.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Шинэ жилээр хүүхдүүдэд өгсөн бэлгийг дотоод журамд зааснаас 259.7 мянган төгрөгөөр илүү зарцуулсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6 “Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцсэн хөдөлмөрийн дотоод журам баталж мөрдүүлэх”, 20.1.7 “Тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах” заалтыг зөрчсөн.

2. Байгууллагад ашиглагдаж байгаа түгээлтийн автомашины замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн торгуулийн төлбөр 350.0 мянган төгрөгийг байгууллагын хөрөнгөнөөс төлсөн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана” заалтыг зөрчсөн.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Болзошгүй өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагад ашиглагдаж байгаа автомашинуудад 260.0 мянган төгрөгийн замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн торгууль бичигдсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18.1 “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана”, 20 дугаар зүйлийн 20.1.7 “Тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах” заалт “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Байгууллагад бүртгэлтэй, үйл ажиллагаандаа ашиглаж буй тээврийн хэрэгсэлтэй холбоотой татвар, хураамж, замын хөдөлгөөн зөрчсөн торгуулийг тухай бүр хянаж, буруутай этгээдээр төлүүлж зөрчлийг арилгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шинэ жилээр хүүхдүүдэд өгсөн бэлгийг дотоод журамд зааснаас илүү зарцуулсан..	1	259.7	1	259.7								
Байгууллагад ашиглагдаж байгаа түгээлтийн автомашины замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн торгуулийн төлбөр байгууллагын хөрөнгөнөөс төлсөн	1	350.0	1	350.0								
Байгууллагад ашиглагдаж байгаа автомашинуудад замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн торгууль бичигдсэн.	1	260.0					1	260.0				
Дүн	3	869.7	2	609.7	-	-	1	260.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд 5 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн.	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Захирлын нэг тушаалыг буруу ангиллаар гаргасан байна.	1	-					1	-
Дүн	2	-					1	-
Нийт дүн	2	-	-	-	-	-	2	-

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР



/Ч.БАЯРСАЙХАН/

/Э.НАНДИНЧИМЭГ/